МОНГОЛ УЛС

ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ

АРХЕОЛОГИЙН ХҮРЭЭЛЭН

МОНГОЛ УЛСЫН АРХЕОЛОГИЧДИЙН ХОЛБОО

Булган аймгийн төвөөс Гурванбулаг сум хүртэл шинээр тавигдах 133 км урттай авто замын трассын дагуух археологийн тандалт судалгаа хийсэн тайлан

Танилцаж баталсан: ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн захирал

Тайлан бичсэн: ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн

доктор, дэд профессор А.Энхтөр

Магистр М.Барс

Улаанбаатар

2012

1 АРХЕОЛОГИ, ТҮҮХ, СОЁЛЫН ДУРСГАЛТ ЗҮЙЛС

1.1 Археологи, түүх, соёлын дурсгалын тандан судалгааны дүн

Хайгуулын талбайн баруун хойд талд Овооны өвөр, Хар толгой гэдэг газар, мөн хайгуулын талбайн дотор баруун дунд хэсэгт Ухаагийн хярын дунд овгорын өвөр зэрэг газруудад булш байсныг бүртгэж тэмдэглэв. Түүнээс гадна хайгуулын талбайн хойт талд хөшөө байсныг баримтжууллаа.

Судалгааны ажлын үндэслэл, шаардлага: Монгол улсын ШУА-ийн Археологийн хүрээлэн нь улсын хэмжээнд археологийн судалгааг дагнан эрхлэн явуулдаг, хяналт тавьдаг мэргэжлийн эрдэм шинжилгээний байгууллага юм.

Монгол Улсын "Соёлын Өвийг хамгаалах тухай" хуулийн 6-р бүлгийн 17-н 10-т : (Хот суурин, барилга байгууламж барих шинээр зам тавих, Усан цахилгаан станц барих, ашигт малтмалын хайгуул хийх, ашиглах зэрэг аж ахуйн үйл ажиллагаа явуулахад зориулан газар олгоход түүх, археологийн мэргэжлийн байгууллагаар хайгуул судалгаа хийлгэж зөвшөөрөл авна) хэмээн заасны дагуу Булган айтгийн төв Булган хотоос Гурван булаг сум хүртэл тавих авто замын трасс дагуух археологийн авран хамгаалах хайгуул судалгааны ажлыг хийж гүйцэтгэх шаардлага бий болсон.

Судалгааны зорилго. Судалгааны ажлын гол зорилго нь археологийн бүх төрлийн дурсгалыг олж илрүүлэн баримтжуулж тодорхойлох юм. Ингэснээр зам тавих үйл ажиллагаанд өртөж болзошгүй түүх, археологийн дурсгалуудыг тодруулж, шаардлагатай тохиолдолд авран хамгаалах малтлага хийх үндэслэлийг тогтооно.

Судалгааны ажлын үр дүнгийн шинэлэг тал, ач холбогдол. Төслийг хэрэгжүүлэх судалгааны ажилд орчин үеийн археологийн шинжлэх ухаанд нэвтэрч буй зарим шинэхэн ололт, дэвшилтэт арга зүйг баримтлан ажиллана. Мөн эртний нүүдэлчдийн ашигт малтмал олзворлож байсан түүхэн болон биет баримтуудыг нягтлан судлах, судалгааны эргэлтэнд оруулах чухал ач холбогдолтой болно. Булган аймгийн Гурванбулаг Хишиг-Өндөр Орхон Булган сумдын нутагт буй археологийн дурсгалыг Монгол улсын түүх соёлын үл хөдлөх дурсгалын бүртгэл мэдээллийн санд бүртгэн авах болно.

Судалгааны үр дүнг ашиглах: Тус төслийн үр дүнд нийтлэгдсэн бүтээлүүдийг бүх шатны түүхийн сургалт, түүнчлэн эх түүхээ сурталчлахад өргөн ашиглах боломжтой. Илэрсэн эх хэрэглэгдэхүүнийг ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн мэдээллийн санд шилжүүлэн судалгаа ба сургалтанд ашиглах болно.

Судалгааны арга. Археологийн хайгуулын орчин үеийн аргуудыг тус хээрийн шинжилгээний ажилд хэрэглэнэ. Голлон археологийн шугаман хайгуулын аргыг хэрэглэнэ. Илэрсэн дурсгалуудын газарзүйн байрлалыг GPS багажаар тогтооно.

Судалгааны ажлын эцсийн үр дүн. Хайгуул судалгааны явцад илрүүлсэн мэдээлэлд тулгуурлан зарим онцлог хэрэглэгдэхүүнийг иж бүрэн судлаж, археологийн дурсгалын сан хөмрөгийг шинэ хэрэглэгдэхүүнээр баяжуулна. Хээрийн судалгааны эрдэм шинжилгээний тайланг зохих шаардлагын дагуу бичиж Археологийн хүрээлэнгийн гар бичмэлийн санд болон захиалагч талд шилжүүлнэ. Үндэсний судлаач эрдэмтдийн хүчээр

судалгаа шинжилгээний ажил явуулсны дүнд шинэ баримт мэдээлэл, мэдлэг, арга зүйг агуулсан хамтын бүтээл өгүүлэл бичнэ.

Экспедицийн маршрут. УБ- Булган- Орхон- Хишиг-Өндөр- Гурванбулаг-чиглэлд явна.

1.2 Дурсгалуудын тодорхойлолт

д/д	Дурсгалын нэр, дугаар	Дурсгалын тодорхойлолт	Солбицол	Тоо ширхэг	Хэмжээ см	Замын трассаас дурсгал хүртэл зай, м
1	Дөрвөлжин булш, №1	Хавтгай том чулуунуудыг дөрвөн талаас нь хавиргалан хийсэн байна (зураг 1).	N48 40 31.3 E103 33 56.8 Alt1075	1	250:200	136
2	Дөрвөлжин булш, №2	Хавтгай чулуунуудыг дөрвөн талаас нь хавиргалан хийсэн байна (зураг 2)	N48 40 31 E103 33 56.7 Alt1075	1	280:200	136
3	Хиригсүүр, №3	Орхон сумын төвөөс хойш 2 км орхон голын зүүн эрэгт байна. Дөрвөлжин хүрээтэй голдоо чулуун овоолготой өндөр нь 1.5 м голын дарааснаас хүрээ хүртэл дундажаар 6 м хэмжээтэй (зураг 3).	N48 40 32.6 E103 33 55.8 Alt1078	1		130
4	Буган чулуун хөшөө, №4	Орхон сумын төвөөс хойш 2км орхон голын зүүн эрэгт байна. Хавтгай гурвалжин хэлбэрийн боржин чулууг засаж нүүрэн талд нь 4 буга. баруун талд нь бамбай. хойд талд нь 3. зүүн талд нь 4 бугыг загварчилсан байдлаар дүрслэн сийлсэн байна (зураг 4).	N48 39 7.4 E103 33 8 Alt 1057	1		326
5	Дөрвөлжин булш, №5	Орхон сумын төвөөс хойш орхон голын зүүн эрэгт байна. 2.5:1.5м хэмжээтэй	N48 39 7.3	1	250:1.5	312

		(зураг 5).	E103 33 8.4 Alt 1057			
6	Дөрвөлжин булш, №6	Орхон сумын төвөөс хойш орхон голын зүүн эрэгт байна. 1.5:2 м хэмжээтэй (зураг 6).	N48 39 7.3 E103 33 8.4 Alt 1056	1	250:1.5	314
7	Дөрвөлжин булш, №7	Орхон сумын төвөөс хойш орхон голын зүүн эрэгт байна. 5:6 м хэмжээтэй (зураг 7).	N48 39 00.6 E103 33 09.3 Alt 1060	1	500:600	258
8	Хиригсүүр, №8	Дөрвөлжин хүрээтэй голдоо чулуун овоолготой өндөр нь 1 м голын дарааснаас хүрээ хүртэл 7 м. Олон тооны дагуултай байна.уг хиригсүүрийн хүрээний баруун хойд өнцөгт 180 см урт 50 см өргөнтэй буган хөшөөг байрлуулсан байсан нь хожим унажээ. Мөн баруун урд өнцөгт нь 2 м урттай 40 см өргөнтэй бас нэгэн буган хөшөөг байрлуулсан байсан нь хожим унасан байна (зураг 8).	N48 38 56.8 E103 33 8 Alt 1055	1		253
9	Хиригсүүр, №9	Дөрвөлжин хүрээтэй дөрвөн өнцөгтөө дагуултай голдоо 1 м өндөр чулуун овоолготой байна (зураг 9).	N48 38 49.6 E103 33 11.7 Alt 1056	1		112

10	Дөрвөлжин булш, №10	(зураг 10)	N48 38 49.1 E103 33 9.8 Alt 1057	1	100:150	144
11	Дөрвөлжин булш, №11	(зураг 11)	N48 38 49.1 E103 33 10 Alt 1058	1	100:200	140
12	Дөрввөлжин булш, №12	Хавтгай чулууг хавиргалан зоосон (зураг 12).	N48 38 49 E103 33 10 Alt 1058	1	250:200	139
13	Хиригсүүр, №13	Дөрвөлжин хүрээтэй голдоо чулуун овоолготой (зураг13).	N48 38 45.2 E103 33 8.9 Alt 1057	1		118
14	Хиригсүүр, №14	Дөрвөлжин хүрээтэй голдоо чулуун овоолготой дөрвөн буландаа дагуултай (зураг 14).	N48 38 44.5 E103 33 8.3 Alt 1058	1		118
15	Хиригсүүр, №15	Дугуй хүрээтэй голдоо чулуун овоолготой. Голч нь 11 м. Уг хиригсүүр нь тоногдсон шижтэй байна (зураг 15).	N48 38 43.3 E103 33 11.3	1		52

			Alt 1054			
16	Булш, №16	Дугуй хүрээтэй чулуун дараас бүхий булш (зураг 16).	N48 35 11.1 E103 33 20.1 Alt 1083	1		
17	Булш, №17	Зууван дугуй хүрээтэй чулуун дараас бүхий булш (зураг 17).	N48 34 48.6 E103 32 55.8 Alt 1097	1	150:200	
18	Хиригсүүр, №18	Дөрвөлжин хүрээтэй дөрвөн буландаа дагуул байгууламжтай голдоо 1 м өндөр чулуун овоолготой зүүн болон урд талдаа 11 дагуултай (зураг 18).	N48 34 15.4 E103 31 31.1 Alt 1092	1		79
19	Дөрвөлжин булш, №19	(зураг 19)	N48 23 24.4 E103 31 42.7 Alt 1388	4		631
20	Хиригсүүр, №20	Хишиг-Өндөрсумын хойно хужиртын голын гүүрний зүүн эрэгт дөрвөлжин хүрээтэй голдоо чулуун овоолготой дагуул байгууламжтай (зураг 20).	N48 18 42.5 E103 26 23.1 Alt 1313	1		174
21	Хиригсүүр, №21	Хишиг-Өндөр сумын хойно Хужиртын голын гүүрний зүүн эрэгт дөрвөлжин	N48 18 39.5	1		55

		хүрээтэй голдоо чулуун овоолготой 12 дагуул байгууламжтай (зураг 21)	E103 26 5.5 Alt 1309			
22	Хиригсүүр, №22	Хиригсүүр дөрвөлжин хүрээтэй голдоо чулуун овоолготой (зураг 22).	N48 18 37.2 E103 26 3.5 Alt 1309	1		45
23	Хиригсүүр, №23	Дөрвөлжин хүрээтэй голдоо чулуун овоолготой (зураг 23).	N48 18 33 E103 25 46.4 Alt 1308	1		240
24	Хиригсүүр, №24	Дөрвөлжин хүрээтэй голдоо чулуун овоолготой дөрвөн буландаа дагуултай (зураг 24).	N48 18 32.7 E103 25 51.7 Alt 1306	1		152
25	Хиригсүүр, №25	Дөрвөлжин хүрээтэй голдоо чулуун овоолготой өмнө зүгрүү чиглэсэн үүдэвчтэй зүүн урд болон баруун талдаа 17 дагуул багууламжтай (зураг 25).	N48 18 28.4 E103 25 48.1 Alt 1307	1		123
26	Хиригсүүр, №26	Дугуй хүрээтэй голдоо чулуун овоолготой (зураг 26).	N48 18 28.9 E103 25 41.4 Alt 1309	1		196
27	Булш, 27	Дугуй хүрээтэй 2 м голчтой булш (зураг 27).	N48 18 27.6	1		169

			E103 25 39 Alt 1308			
28	Хиригсүүр, №28	Дөрвөлжин хүрээтэй голдоо чулуун овоолготой дөрвөн буландаа дагуултай (зураг 28).	N48 18 27.9 E103 25 37.6 Alt 1310	1		168
29	Хиригсүүр, №29	Дугуй хүрээтэй голдоо чулуун овоолготой (зураг 29).	N48 18 21.4 E103 25 31 Alt 1304	1		3
30	Хиригсүүр, №30	Хишиг-Өндөр сумын төвийн хойд захад дөрвөлжин хүрээтэй голдоо чулуун овоолготой дөрвөн буландаа дагуултай (зураг 30).	N48 18 21.9 E103 25 24.3 Alt 1305	1		37
31	Хиригсүүр, №31	Дөрвөлжин хүрээтэй голдоо чулуун овоолготой 13 дагуул байгууламжтай (зураг 31).	N48 18 20.1 E103 25 2.4 Alt 1300	1		52
32	Буган чулуун хөшөө, №32	2 м урт 60 см өргөн 24 см зузаан боржин чулуунд дээд хэсэгт нь нар сар дундуур нь 5 ш бугыг загварчлан дүрсэлж сийлсэн байна (зураг 32).	N48 18 54.6 E103 26 15.7 Alt 1311	1	180:60:24	178
33	Хиригсүүр,	Дөрвөлжин хүрээтэй голдоо чулуун	N48 18 52.4	1		190

	№33	овоолготой (зураг 33).	E103 26 12.3 Alt 1315			
34	Хиригсүүр, №34	Дөрвөлжин хүрээтэй голдоо чулуун овоолготой дөрвөн буландаа босоо чулуутай (зураг 34).	N48 18 52 E103 26 10 Alt 1314	1		221
35	Хиригсүүр, №35	Дугуй хүрээтэй голдоо чулуун овоолготой (зураг 35).	N48 18 51.8 E103 26 9.3 Alt 1321	1		229
36	Хиригсүүр, №36	Дугуй хүрээтэй чулуун овоолготой дөрвөн талдаа дагуул байгууламжтай (зураг 36).	N48 18 51 E103 26 10.2 Alt 1320	1		199
37	Хиригсүүр, №37	Дөрвөлжин хүрээтэй голдоо чулуун овоолготой (зураг 37).	N48 18 51.1 E103 26 9.9 Alt 1316	1		206
38	Хиригсүүр, №38	Дөрвөлжин хүрээтэй голдоо чулуун овоолготой (зураг 38).	N48 18 49.7 E103 26 10.6 Alt 1314	1		166
39	Хиригсүүр,	Дөрвөлжин хүрээтэй. голдоо чулуун овоолготой. үүдэвчтэй. Уг хиригсүүр нь 29	N48 18 48.4	1		134

	№39	дагуул байгууламжтай (зураг 39).	E103 26 12.7 Alt 1316			
40	Хиригсүүр, №40	Дугуй хүрээтэй голдоо чулуун овоолготой (зураг 40).	N48 18 47.1 E103 26 15.4 Alt 1316	1		65
41	Хиригсүүр, №41	Дөрвөлжин хүрээтэй. голдоо чулуун овоолготой. Зүүн талдаа 3-н эгнээ цуваа байрлалтай 28ш дагуул байгууламжтай (зураг41).	N48 00 38.4 E103 20 01.7 Alt 1474	1		1021
42	Хиригсүүр, №42	Дөрвөлжин хүрээтэй. голдоо чулуун овоолготой. Зүүн талдаа 12 ш дагуул байгууламжтай (зураг42).	N48 00 33.6 E103 19 53.6 Alt 1475	1		1201
43	Хиригсүүр, №43	Дөрвөлжин хүрээтэй. голдоо чулуун овоолготой. Зүүн талдаа цуваа байрлалтай 8ш дагуул байгууламжтай. баруун болон хойд буландаа босоо том чулуутай(зураг43).	N48 00 35.5 E103 19 51.2 Alt 1480	1		1228
44	Хиригсүүр, №44	Хиригсүүр дугуй хүрээтэй чулуун овоолготой дөрвөн талдаа дагуул байгууламжтай. Зүүн талдаа 8ш дагуул байгууламжтай (зураг44).	N48 00 38.2 E103 19 25.2 Alt 1502	1		1789
45	Хиригсүүр,	Дугуй хүрээтэй чулуун овоолготой 6м	N48 00 37.6	1		1666

	№45	голчтой (зураг45).	E103 19 30.6 Alt 1497			
46	Булш, №46	Дугуй хүрээтэй чулуун дараас бүхий булш. Гурван булаг сум. Авзага баг Баян жлаан уулын зүүн бэлд 2.5 м голчтой (зураг46).	N47 55 03.1 E103 21 39.5 Alt 1289	1		386

Монгол орны төвийн бүст тавьж буй авто зам нь улс орны эдийн засаг, аялал жуулчлал, бүс нутгийн хөгжилд ихээхэн ач холбогдолтой бөгөөд асар их хэмжээний бүтээн байгуулалт явагдах нь ойлгомжтой. Үүнийг дагаад түүх археологийн соёлын өвийн дурсгалууд өртөж устах аюултай юм. Авто замын дагуух археологийн дурсгалыг тандан судлах ажлын хүрээнд Булган аймгийн төв Булган хотоос Гурванбулаг сумын чиглэлд тавигдах 133 км авто замын трассын дагуу археологийн урьдчилсан хайгуул хийж үзэхэд хиргисүүр 30, дөрвөлжин булш 9, буган чулуун хөшөө 4 байна. Эдгээрээс авто зам тавих үйл ажиллагаанд өртөж сүйдэхээр дурсгал 1 байна. Уг дурсгал (N481821,3 E1032330,9) нь Хишиг-Өндөр сумын төвийн хойно замын трасст дайрагдаж байна. Хэрэв авто замын трассыг өөрчлөх тохиолдолд ШУА-ийн археологийн хүрээлэнд мэдэгдэж, шаардлагатай тохиолдолд дахин археологийн хайгуул хийлгэнэ. Эдгээрийг дээрх маршрутын дагуу тавих тохиолдолд соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 6-р бүлгийн 17-10-д заасны дагуу археологийн авран хамгаалах малтлага судалгаа хийж талбайг чөлөөлөх нь зүйтэй юм.

1.3 Авто замын барилгын ажлыг гүйцэтгэх үед соёлын өвийг хамгаалах

1. Авто замын барилгын ажлын үед Соёлын өвийг хамгаалах үйл ажиллагааг Монгол улсын соёлын өвийн тухай хууль /2001 он/, түүнд холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу явуулна.
2. Соёлын өвийг хамгаалах арга хэмжээ зохицуулах эрх зүйн гол бичиг баримт нь монгол улсын соёлын өвийн тухай хууль /2001 он/, Монгол улсын нутагт археологи, палеонтологийн хайгуул, малтлага, судалгаа хийх журам /боловсрол, соёл, шинжлэх ухаан сайдын 2010 оны 5 сарын 18 -ны өдрийн 222 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт, мөн байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль /1998 он/ болно.
3. Төлөвлөж буй авто замын трасст өртөж буй соёлын өвд Монгол улсын соёлын өвийн тухай хуулийн 6-р бүлгийн 17.10-д “Хот суурин, барилга байгууламж барих, шинээр зам тавих, усан цахилгаан станц байгуулах, ашигт малтмалын хайгуул хийх, ашиглах, зэрэг аж ахуйн үйл ажиллагаа явуулахад зориулан газар олгоход түүх, археологийн мэргэжлийн байгууллагаар урьдчилан хайгуул, судалгаа хийлгэж, түүнээс зөвшөөрөл авна. Урьдчилан хайгуул хийлгэх, илэрсэн түүх, соёлын дурсгалт зүйлийг авран хамгаалах ажилд шаардагдах зардлыг барилга байгууламжийн захиалагч хариуцна” гэж заасны дагуу мэргэжлийн байгууллагаар /трасс дагуу өмнө нь тандан судалгаа хийсэн ШУА-ийн Археологийн хүрээлэн/ авран хамгаалах малтлага хийх, шилжүүлэх арга хэмжээг гэрээний үндсэн дээр зам барилгын ажил эхлэхийн өмнө гүйцэтгүүлнэ. Мөн соёлын өвийг хамгаалах талаар мэргэжлийн зөвлөмж авч хэрэгжүүлнэ. Дээрх арга хэмжээг хэрэгжүүлэх Монгол улсын нутагт археологи, палеонтологийн хайгуул, малтлага, судалгаа хийх журмын 2.2-д “Археологи, палеонтологийн хайгуул, малтлага, судалгааг мэргэжлийн эрдэм шинжилгээний байгууллага эрхлэн явуулна.”, мөн журмын 2.4-д “Хот, суурин,

барилга байгууламж, усан цахилгаан станц, уул уурхайн үйлдвэр барьж байгуулах, зам тавих зэрэг үйл ажиллагаа явуулах аж ахуйн нэгж нь уг ажлыг эхлэхийн өмнө мэргэжлийн зөвлөлд хандах бөгөөд зөвлөл нь мэргэжлийн шинжээчдийг томилон тухайн газар нутагт түүх, археологийн дурсгалт зүйл байгаа эсэх талаар тандалтын урьдчилсан малтлага, судалгаа хийлгэж дүгнэлт гаргуулна.", 2.5-д "Тандалтын малтлага, судалгаа хийх, олдворыг авран хамгаалах ажилд шаардагдах зардлыг энэ журмын 2.4-т заасан үйл ажиллагаа явуулах аж ахуйн нэгж хариуцна." гэснийг баримтална.

4. Авто замын барилгын ажлын үед хамгаалах соёлын өвд авто замын трасс, ашигт малтмал ашиглах карьер орчмын хөшөө дурсгал, хүн чулуу, эртний хотын туурь, эртний хүмүүсийн бууц, булш, хиргисүүр, зан үйлийн байгууламжууд зэргийг хамруулж авч үзнэ.
5. Авто замын трасс, карьерт өртөгдөх байдлыг харгалзан авран хамгаалах малтлага хийх, шилжүүлэх арга хэмжээг трассын голын цэгээс 25 м-т байгаа соёлын өвд, замын барилга байгууламжийн үйл ажиллагаанд өртөхөөс хамгаалах арга хэмжээг трассын голоос 25-50 м-т байгаа соёлын өвд хамруулна. Түүнчлэн карьерт 50 м –т ойр байгаа соёлын өвийг уг арга хэмжээнд хамруулна.
6. Хэрвээ зам барилгын ажлын үед газрын хэвлийд соёлын өв илэрвэл Монгол улсын соёлын өвийн тухай хуулийн 6-р бүлгийн 17.11-д "Иргэн түүх, соёлын дурсгалт зүйлд аюул учирч байгаа, эсхүл учирч болзошгүй байдал олж илрүүлсэн бол энэ тухай холбогдох байгууллага, албан тушаалтанд нэн даруй мэдэгдэх, боломжтой бол хамгаалах арга хэмжээ авах үүрэгтэй" гэж заасны дагуу арга хэмжээ авах үүрэг хүлээнэ. Мөн уг хуулийн 17.12-д "Газрын хэвлийг ашиглах явцад түүх, соёлын дүрсгалт зүйл илэрвэл газрын хэвлийг ашиглагч нь ажлаа зогсоож энэ тухай сум, дүүргийн Засаг дарга, цагдаагийн болон уг асуудлыг эрхэлсэн эрдэм шинжилгээний байгууллагад нэн даруй мэдэгдэнэ." гэж заасны дагуу арга хэмжээ авч хамгаалах үүрэг хүлээнэ.
7. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд заасны дагуу "төсөл хэрэгжих газрын түүх соёлын үнэт зүйлс, төслийн онцлогтой уялдсан асуудал"-ыг судалж сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээг зөвлөх, төлөвлөх талаар байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланд тусгасан байдаг тул уг төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээнд соёлын өвийг хамгаалах талаар заасан арга хэмжээг барилгын ажлын үед бүрэн хэрэгжүүлэх үүргийн төсөл хэрэгжүүлэгч хүлээнэ.

1-р хавсралт. Авто замын трассын дагуух дурсгалуудын гэрэл зураг болон байрлалын зураг

Зураг 1

Зураг 2

Зураг 3

Зураг 4

Зураг 5

Зураг 6

Зураг 7

Зураг 8

Зураг 8

Зураг 8

Зураг 9

Зураг 10, 11

Зураг 12

Зураг 13



Зураг 14

Зураг 15

Зураг 16

Зураг 17

Зураг 18

Зураг 19

Зураг 20

Зураг 21

Зураг 22

Зураг 23

Зураг 24

Зураг 25

Зураг 26

Зураг 27

Зураг 28

Зураг 29

Зураг 30

Зураг 31

Зураг 32

Зураг 33

Зураг 34

Зураг 35

Зураг 36

Зураг 37

Зураг 38

Зураг 39

Зураг 40

Зураг 41

Зураг 42

Зураг 43

Зураг 44

Зураг 45

Зураг 46





Дурсгал

Замын трасст өртөж буй дурсгал





★ Дурсгал

★ Замын трасст өртөж буй дурсгал



Дурсгал

Замын трасст өртөж буй дурсгал



Дурсгал

Замын трасст өртөж буй дурсгал